



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/76

Алтрага

Хүлээж авах хяналт тавих  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн “Малчдын зөвлөгөөн зохион байгуулах” ажлыг хүлээж авах, хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Даваажав  
(Мал эмнэлгийн улсын байцаагч)  
Гишүүн: Г.Батнасан  
(Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал  
хариуцсан мэргэжилтэн)  
Нарийн бичгийн дарга: Н.Лхагвадулам  
(Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний  
хяналтын улсын байцаагч)

2.2024 оны сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн “Малчдын зөвлөгөөн зохион байгуулах” ажлыг хууль журмын хүрээнд хүлээж авахыг Ажлын хэсгийн ахлагч (Ж.Даваажав)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Г.ОДСЭР

Document-Zahiramg

6729010176